



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тонхил сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/127/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhand@audit.gov.mn Төгс нотолгоо аудит ХХК-ийн Ахлах аудитор: Г.Цэцэгмаа Утас: 99889665 Цахим хаяг: togsnotolgoo_audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

᠒᠐᠒᠖. ᠐᠒. 1᠖ № ᠖᠐

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу дагуу Тонхил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Үүнд:

- Тайлант оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй,
- Тус сургууль нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих Хяналтын зөвлөл байгуулаагүй, гарал үүслийн болон шинжилгээний бичиг баримтгүй хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авсан, ханган нийлүүлэгчтэй гэрээ байгуулдаггүй,
- Сургуулийн дотуур байр, үдийн цайны үйлчилгээ, бүтээгдэхүүний шим тэжээл, илчлэг, хоолны орцонд сургуулийн эмч өдөр тутмын хяналт тавьж ажиллаагүй,
- Тайлант оны 3 дугаар улирлын байдлаар 1422.8 кг буюу 11,278.2 мянган төгрөгийн мах, 3 нэр төрлийн 164.7 мянган төгрөгийн хүнсний материал, 10, 11 дүгээр сард 183.8 кг буюу 1,378.5 мянган төгрөгийн мах дутагдсан зэрэг зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн

ТОНХИЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ГАНЧУЛУУН ТАНАА

822511000375

37.1.13, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 8.1, 13.7, 20.1.4 дэх заалтууд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/140 дүгээр тушаалын хавсралт" 2.5.1, 2.5.2, 2.5.3, 20.2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн санхүүжилт 188,005.5 мянган төгрөгөөр, орон нутгаас авах санхүүжилт 97,969.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сургуулийн дотуур байр, үдийн цайны үйлчилгээнд сургуулийн эмч өдөр тутмын хяналт тавьж ажиллаагүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэгчтэй гэрээ байгуулаагүй, дотуур байр, үдийн цайны үйлчилгээг шаардлагын хэмжээнд зохион байгуулаагүй, хоолны орц, бүтээгдэхүүний шим тэжээл, илчлэг алдагдаж, батлагдсан жор, технологийн журмыг баримталж ажиллаагүй байна.

Бусад асуудал

Тайлант онд 1 хөтөлбөр, 12 зорилт, 76 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 45 арга хэмжээг бүрэн, 31 арга хэмжээг дутуу, нийт дүнгээр 82.2 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Боловсролын газраас 70.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,578,714.90	193,204,530.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	147,651,695.81	68,450,810.40
3121	Төгрөг	147,651,695.81	68,450,810.40
31211	Төрийн сангийн харилцах	147,651,695.81	68,450,810.40
33	АВЛАГА	2,316,090.00	2,266,640.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	848,010.00	848,010.00
335	Бусад авлага	1,468,080.00	1,418,630.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,418,630.00	1,418,630.00
35	БАРАА МАТЕРИАЛ	106,610,929.09	122,487,080.01
351	Түүхий эд материал	23,415,209.09	42,434,360.01
35110	Тусгай зориулалттай материал	23,315,209.09	42,434,360.01
354	Хангамжийн материал	83,195,720.00	80,052,720.00
35420	Аж ахуйн материал	48,200,000.00	61,192,000.00
35460	Хүнсний материал	34,995,720.00	18,860,720.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,030,611,318.75	891,042,418.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,030,611,318.75	891,042,418.42
392	Биет хөрөнгө	942,131,427.00	805,009,426.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	709,601,665.49	709,601,665.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(208,835,563.70)	(242,227,867.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,541,666.53)	(11,041,666.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	790,396,433.18	809,969,933.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(454,521,659.73)	(543,437,772.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	121,339,976.20	121,339,976.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(70,447,232.55)	(81,586,508.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,467,338.20	53,467,338.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(30,750,671.56)	(36,075,671.56)
393	Биет бус хөрөнгө	88,479,891.75	86,032,991.79
39301	Програм хангамж	10,767,600.00	10,767,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,077,708.25)	(8,524,608.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	83,790,000.00	83,790,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,287,190,033.65	1,084,246,948.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	57,324,333.35	3,461,250.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	57,324,333.35	3,461,250.00
413	Өглөг	57,324,333.35	3,461,250.00
4136	Бусад өглөг	-	3,461,250.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,461,250.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,229,865,700.30	1,080,785,698.83
51	Засгийн газрын хувь оролцоо	1,229,865,700.30	1,080,785,698.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	620,547,981.58	620,547,981.58
51101	Өмч: - төрийн	620,547,981.58	620,547,981.58
512	Хуримтлагдсан үр дүн	86,796,957.88	(62,283,043.59)
51210	Өмнөх үеийн үр дүн	(79,417,494.24)	86,796,957.88
51220	Тайлант үеийн үр дүн	166,214,452.12	(149,080,001.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	522,520,760.84	522,520,760.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,287,190,033.65	1,084,246,948.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,252,645,268.20	2,321,890,513.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,644,968.20	10,914,720.92
120	Нийтлэг татварын бус орлого	227,644,968.20	10,914,720.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,763,800.00	3,459,178.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,893,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,763,800.00	565,378.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,842,389.20	7,455,542.92
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,025,000,300.00	2,310,975,792.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,741,981,000.00	1,929,986,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,741,981,000.00	1,929,986,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	283,019,300.00	380,989,292.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	283,019,300.00	380,989,292.34
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,086,430,816.04	2,470,970,514.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,086,430,816.04	2,470,970,514.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,046,108,506.04	2,413,886,414.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,334,017,989.00	1,635,981,080.00
210101	Үндсэн цалин	865,241,833.00	959,412,221.00
210102	Нэмэгдэл	441,779,406.00	587,608,654.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,811,003.00
210104	Урамшуулал	26,996,750.00	50,149,202.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,590,868.59	197,319,811.92
210201	Тэтгэврийн даатгал	114,397,424.59	134,752,438.92
210202	Тэтгэмжийн даатгал	13,493,434.00	16,077,796.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,742,392.00	8,038,996.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,591,663.00	7,696,446.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,365,955.00	30,754,135.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,509,466.35	315,843,725.99
210301	Гэрэл, цахилгаан	10,877,914.35	16,212,173.99
210302	Түлш, халаалт	299,631,552.00	299,631,552.00
2105	Нормативт зардал	33,866,680.00	44,910,880.00
210502	Хоол, хүнс	33,866,680.00	44,910,880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,655,400.00	12,600,000.00
210604	Урсгал засвар	17,655,400.00	12,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,186,022.38	21,370,996.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,933,000.00	2,861,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,253,022.38	18,509,496.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,282,079.72	185,859,920.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,426,115.00	31,843,328.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,597,100.00	10,297,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	112,258,864.72	143,719,592.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,322,310.00	57,084,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,822,310.00	57,084,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,822,310.00	57,084,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	166,214,452.16	(149,080,001.47)
1	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	166,214,452.16	(149,080,001.47)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,049,764,100.00	2,314,484,420.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,763,800.00	3,508,628.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,763,800.00	3,508,628.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,763,800.00	3,508,628.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,893,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,763,800.00	614,828.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,025,000,300.00	2,310,975,792.34
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,741,981,000.00	1,929,986,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,741,981,000.00	1,929,986,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	283,019,300.00	380,989,292.34
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	283,019,300.00	380,989,292.34
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,937,725,572.97	2,374,111,805.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,937,725,572.97	2,374,111,805.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,890,596,242.97	2,326,419,455.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,333,358,472.00	1,636,640,597.00
210101	Үндсэн цалин	864,582,316.00	960,071,738.00
210102	Нэмэгдэл	441,779,406.00	587,608,654.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,811,003.00
210104	Урамшуулал	26,996,750.00	50,149,202.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,590,868.59	197,319,811.92
210201	Тэтгэврийн даатгал	114,397,424.59	134,752,438.92
210202	Тэтгэмжийн даатгал	13,493,434.00	16,077,796.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,742,392.00	8,038,996.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,591,663.00	7,696,446.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,365,955.00	30,754,135.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,363,900.00	370,989,292.34
210301	Гэрэл, цахилгаан	10,500,000.00	16,590,088.34
210302	Түлш, халаалт	244,863,900.00	354,399,204.00
2105	Нормативт зардал	42,262,030.00	36,150,430.00
210502	Хоол, хүнс	42,262,030.00	36,150,430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,655,400.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	17,655,400.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,186,022.38	21,370,996.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,933,000.00	2,861,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,253,022.38	18,509,496.49
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,679,550.00	53,948,328.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,082,450.00	43,604,828.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,597,100.00	10,343,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,129,330.00	47,692,350.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,629,330.00	47,692,350.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,629,330.00	47,692,350.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	112,038,527.03	(59,627,385.41)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	42,864,500.00	19,573,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,864,500.00	19,573,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,864,500.00	19,573,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,864,500.00	19,573,500.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(42,864,500.00)</u>	<u>(19,573,500.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	69,174,027.03	(79,200,885.41)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	78,477,668.78	147,651,695.81
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	147,651,695.81	68,450,810.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	620,547,981.58	522,520,760.84	(69,303,494.24)	1,073,765,248.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(10,114,000.00)	(10,114,000.00)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	620,547,981.58	522,520,760.84	(79,417,494.24)	1,063,651,248.18
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	166,214,452.16	166,214,452.16
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	620,547,981.58	522,520,760.84	86,796,957.92	1,229,865,700.34
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	620,547,981.58	522,520,760.84	86,796,957.92	1,229,865,700.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	620,547,981.58	522,520,760.84	86,796,957.92	1,229,865,700.34
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(149,080,001.47)	(149,080,001.47)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	620,547,981.58	522,520,760.84	(62,283,043.55)	1,080,785,698.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	БАТАЛСАН ТӨСӨВ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,491,481,000.0	2,393,685,305.75	97,795,694.25	96.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,491,481,000.0	2,393,685,305.8	97,795,694.3	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,440,617,200.0	2,345,992,955.75	94,624,244.3	96.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,685,736,800.0	1,636,640,597.00	49,096,203.0	97.1
210101	Үндсэн цалин	1,046,859,200.0	960,071,738.00	86,787,462.0	91.7
210102	Нэмэгдэл	597,691,300.0	587,608,654.00	10,082,646.0	98.3

**Говь-Алтай аймгийн Тонхил сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,811,003.00	(38,811,003.0)	-
210104	Урамшуулал	41,186,300.0	50,149,202.00	(8,962,902.0)	121.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	207,238,500.0	197,319,811.92	9,918,688.1	95.2
210201	Тэтгэврийн даатгал	139,808,800.0	134,752,438.92	5,056,361.1	96.4
210202	Тэтгэмжийн даатгал	16,857,300.0	16,077,796.00	779,504.0	95.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,428,800.0	8,038,996.00	389,804.0	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	8,428,800.0	7,696,446.00	732,354.0	91.3
210205	Эрүүл мэндийн даатгал	33,714,800.0	30,754,135.00	2,960,665.0	91.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	389,272,500.0	370,989,292.34	18,283,207.7	95.3
210301	Гэрэл, цахилгаан	11,000,000.0	16,590,088.34	(5,590,088.3)	150.8
210302	Түлш, халаалт	378,272,500.0	354,399,204.00	23,873,296.0	93.7
2105	Нормативт зардал	37,340,200.0	36,150,430.00	1,189,770.0	96.8
210502	Хоол, хүнс	37,340,200.0	36,150,430.00	1,189,770.0	96.8
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	10,000,000.0	10,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.0	10,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,630,400.0	21,370,996.49	6,259,403.5	77.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,046,700.0	2,861,500.00	185,200.0	93.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,583,700.0	18,509,496.49	6,074,203.5	75.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,398,800.0	73,521,828.00	9,876,972.0	88.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,039,800.0	63,178,328.00	9,861,472.0	86.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,359,000.0	10,343,500.00	15,500.0	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,863,800.00	47,692,350.00	3,171,450.00	93.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,863,800.0	47,692,350.00	3,171,450.0	93.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,863,800.0	47,692,350.00	3,171,450.0	93.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,491,481,000.00	2,393,685,305.75	97,795,694.25	96.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,942,803,800.00	1,929,986,500.00	12,817,300.00	99.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,942,803,800.00	1,929,986,500.00	12,817,300.00	99.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	399,272,500.00	380,989,292.34	18,283,207.66	95.4
132001	Орон нутгийн төсвөөс	399,272,500.00	380,989,292.34	18,283,207.66	95.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	149,404,700.00	82,709,513.41	66,695,186.59	55.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,916,700.00	2,893,800.00	3,022,900.00	48.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	530,400.00	614,828.00	-84,428.00	115.9
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	142,957,600.00	79,200,885.41	63,756,714.59	55.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		147,651,695.81		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		68,450,810.40		

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 43,292.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 5 алдаа¹-г аудитын явцад залруулж, тайлагнаж ирснийг баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Үр дүнгийн тайланд 6,725.0 мянган төгрөгийн бараа материал акталж устгасныг шуудан холбооны зардалд тайлагнасан,
- Монголын цахилгаан холбоо ХХК-д гэрээний дагуу утасгүй интернэтийн үйлчилгээ төхөөрөмжийн үлдэгдэл болох 19,114.5 мянган төгрөгийг 2024 онд өглөгөөр тусгаагүй хөрөнгийг үнийн дүн зөрүүтэй орлого авсан,
- Завсрын аудитын явцад хүнсний материалын биет тооллого хийхэд сурагчдаас үнэ төлбөргүй авсан ааруулыг эд хариуцагчийн тайлан, нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй агуулахад 100 кг ааруул тоологдсон,
- Харилцах дансны үлдэгдлийг 30.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 15,422.8 мянган төгрөгийн сурах бичгийг бараа материалын дансанд шилжүүлэхдээ үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар буруу тайлагнасныг залруулсан.

Залруулагдаагүй нийт 16,948.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 16,948.6 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс 12,821.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 сахилгын хариуцлага тооцох албан шаардлага, 4,121.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн.

3.2 Төлбөрийн акт

Аудитын явцад 3 дугаар улирлын байдлаар нягтлан бодох бүртгэлд үлдэгдлээр тайлагнасан 16,454.4 мянган төгрөгийн хүнсний материалд биет тооллого хийхэд 1,422.8 кг буюу 11,278.2 мянган төгрөгийн мах, 3 нэр төрлийн 164.7 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан ба 2023 оноос хойш нягтлан бодох бүртгэлд хүнсний материалын үлдэгдлээр тайлагнагдсан байна. Мөн 2025 оны 10, 11 дүгээр сарын махны орлого болон менюны зарлагыг тооцоолж үзэхэд 183.8 кг буюу 1,378.5 мянган төгрөгийн мах дутагдаж төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулаагүй материаллаг зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/140 дүгээр тушаалын хавсралт" 2.5.1-т "батлагдсан цэсийн дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг бүтээгдэхүүний хорогдлыг тооцсон дүнгээр захиалга хийх", 2.5.2-т "хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлэгчээс Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.6-д заасан журмын дагуу хүлээн авах", 2.5.3-т "хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг шинж чанараас шалтгаалж 7-21 хүртэлх хоногийн нөөцтэй байхаар бэлтгэн, хадгалах" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт

3.3 Албан шаардлага

Сургуулийн дотуур байр, үдийн цайны үйлчилгээнд сургуулийн эмч өдөр тутмын хяналт тавьж ажиллаагүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэгчтэй

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлээгүй, талуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавиагүй, дотуур байр, үдийн цайны үйлчилгээг шаардлагын түвшинд зохион байгуулаагүй, бүтээгдэхүүний орц нормд хоолны менюгээр хонины мах гэж бичсэн боловч анхан шатны баримтыг үндэслэн шалгахад тэмээний мах их хэмжээгээр хэрэглэсэн нь хоолны орц, бүтээгдэхүүний шим тэжээл, илчлэг алдагдаж, батлагдсан жор, технологийн журмыг баримталж ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаалын хавсралт "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам" 2.2-т "Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгч /аж ахуйн нэрж байгууллага, хоршоо, нөхөрлөл, бүлэг(нэгдэл), хуулийн этгээд/-тэй хичээлийн жилийн эхэнд гэрээ байгуулж ажиллана." 2.6-т "Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захиралтай гэрээ байгуулаагүй гуравдагч этгээдээр дамжуулан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургуулийн захирал Д.Ганчулуун, нягтлан бодогч Г.Баясгалан, нярав Д.Алтайбаатар, эмч Т.Ариунзаяа, тогооч Н.Нямсайхан, Б.Мөнхцэцэг, Л.Ононтуул нарт хуулийн дагуу сахилгын хариуцлага тооцох.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Баталсан төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичгийг үндэслэн тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцон цалингийн зардлаас 24,395.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан төсвийн хүрээнд зарцуулах.

Хоёр. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хичээл үйлдвэрлэлийн зардлаас физикийн олимпиадад оролцсон гаднын багшид 415.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн, сургалтын төлбөрт 3,000.0 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтгүй гүйлгээ хийхгүй байх.

Гурав. Цалингийн зардлын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байхад 8 дугаар сард албан хаагчид 706.6 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах.

Дөрөв. Хоолны зардлын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сургууль нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих хяналтын зөвлөл байгуулаагүй, хүнсний хангамж, үйлчилгээтэй холбоотой сургалт, үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалтын дүн, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн болон шинжилгээний бичиг баримтгүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүн худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаалын хавсралт "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/ дотуур байрны хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам" 2.2-т "Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгч /аж ахуйн нэгж байгууллага, хоршоо, нөхөрлөл, бүлэг(нэгдэл), хуулийн этгээд/ -тэй хичээлийн жилийн эхэнд гэрээ байгуулж ажиллана." 2.6-т "Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захиралтай гэрээ байгуулаагүй гуравдагч этгээдээр дамжуулан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэхийг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих хяналтын зөвлөлийг байгуулан, хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
								тоо	Дүн	тоо	Дүн			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	
Говь-Алтай аймгийн Тонхил сумын ерөнхий боловсролын сургууль	Үр дүнгийн тайланд 6,725.0 мянган төгрөгийн бараа материал акталж устгасныг шуудан холбооны зардалд тайлагнасан.	1	6,725.00			1	6,725.00	1	6,725.00			-	-	-
	"Монголын цахилгаан холбоо" ХХК-д гэрээний дагуу утасгүй интернэтийн үйлчилгээ төхөөрөмжийн үлдэгдэл болох 19,114.5 мянган төгрөгийг 2024 онд өглөгөөр тусгаагүй хөрөнгийг үнийн дүн зөрүүтэй орлого авсан.	1	19,114.5			1	19,114.5	1	19,114.5					
	Завсрын аудитын явцад хүнсний материалын биет тооллого хийхэд сурагчдаас үнэ төлбөргүй авсан ааруулыг эд хариуцагчийн тайлан, нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй агуулахад 100 кг ааруул тоологдсон.	1	2,000.00		1	2,000.00			1	2,000.00				
	Харилцах дансны үлдэгдлийг 30.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	30.00				1	30.00	1	30.00				
	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 15,422.8 мянган төгрөгийн сурах бичгийг бараа материалын дансанд шилжүүлэхдээ үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар буруу тайлагнасан.	1	15,422.80				1	15,422.80	1	15,422.80				
Дүн		5	43,292.3	1	2,000.0	4	41,292.3	5	43,292.3		-	-	-	

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1		3	4	5	6	7	8	9	10	11	12
	Хичээл үйлдвэрлэлийн зардлаас физикийн олимпиадад оролцсон гаднын багшид 415.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн, сургалтын төлбөрт 3,000.0 мянган төгрөгийг анхан шатны нотлох баримтгүйгээр зарцуулсан.	1	3,415.0	-	-	-	-	1	3,415.0	-	-
Говь-Алтай аймгийн Тонхил сумын ерөнхий боловсролын сургууль	Аудитын явцад 3-р улирлын байдлаар нягтлан бодох бүртгэлд үлдэгдлээр тайлагнасан 16,454.4 мянган төгрөгийн хүнсний материалд биет тосллого хийхэд 1,422.8 кг буюу 11,278.2 мянган төгрөгийн мах, 3 нэр төрлийн 164.7 мянган төгрөгийн хүнсний материал дутагдсан. Энэ нь 2023 оноос хойш нягтлан бодох бүртгэлд хүнсний материалын үлдэлдэлтэй тайлагнасан байна. Мөн 2025 оны 10, 11 сарын махны орлого болон менюны зарлагыг тооцоолж үзэхэд 183.8 кг буюу 1,378.5 мянган төгрөгийн мах дутсан нь төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулаагүй.	1	12,821.4	1	12,821.4	-	-	-	-	-	-
	Сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байхад 8 дугаар сард албан хаагчид 706.6 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон.	1	706.6	-	-	-	-	1	706.6	-	-
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож цалингийн зардлаас 38,811.0 мянган төгрөгийг олгосон.	1		-	-	-	-	1		-	-

Говь-Алтай аймгийн Тонхил сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

	<p>Сургуулийн дотуур байр, үдийн цайны үйлчилгээнд сургуулийн эмч өдөр тутмын хяналт тавьж ажиллаагүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлээгүй, талуудын гэрээний хэрэгжилтэд хяналт хийгээгүй, дотуур байр, үдийн цайны үйлчилгээг шаардлагын хэмжээнд зохион байгуулаагүй, дотуур байрны хоол, үдийн цайнд тавих өдөр тутмын тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, бүтээгдэхүүний орц нормд хоолны мөнгөгээр хонины мах гэж бичсэн боловч анхан шатны баримтыг үндэслэн шалгахад тэмээний мах их хэмжээгээр хэрэглэсэн нь хоолны орц, бүтээгдэхүүний шим тэжээл, илчлэг алдагдаж, батлагдсан жор, технологийн журмыг баримталж ажиллаагүй.</p>	1	-	-	-	1	-	-	-	-	-
	<p>Тус сургууль нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих хяналтын зөвлөл байгуулаагүй, хүнсний хангамж, үйлчилгээтэй холбоотой сургалт, үйл ажиллагааны тайлан, хяналт шалгалтын дүн, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн болон шинжилгээний бичиг баримт байхгүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүн худалдан авсан.</p>	1	-	-	-	-	-	1	-	-	-
		6	16,948.0	1	12,821.4	1	-	4	4,121.6	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		